

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
БАГАЧУУД ХҮНС ОНӨААТҮГ-ЫН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛСАН
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 04

Улаанбаатар хот

№	Удирдах ажилтны хүлээсэн үүрэг	Биелэлт	Хувь
1	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	2024 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл дунд хугацааны төлөвлөлтийн зорилт арга хэмжээний биелэлт, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг холбогдох хүснэгтээр хугацаанд нь тайлагнан хүргүүлж ажилласан.	100%
2	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах;	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу байгууллагын бүтэц орон тооны дутагдалтай эрүүл ахуйч-1, түгээлтийн нярав-1, жолооч-3, ачигч-4 сул орон тоог тус бүр байгууллагын bagachuudkhuns.ub.gov.mn цахим хуудас болон facebook хаягаар зарлаж, нийт 9 ажилтанг сонгон шалгаруулж томилсон. Тайлант хугацаанд сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан ажилтан байхгүй болно.	100%
3	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хэвийн ажиллагааг ханган ажиллаж байгаа бөгөөд 2024 онд нийт 5,823,002.80 мянган төгрөгийн борлуулалтын орлого олж 7,862,963.18 мянган төгрөгийн зардал гарган 72,201.94 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан бөгөөд 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4,549,436.91 мянган төгрөгийн орлого олж 4,505,269.45 мянган төгрөгийн зардал гарган 29,750.71 мянган төгрөгийн ашигтай урьдчилсан гүйцэтгэлтэй ажиллаж байна.	100%
4	Хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;	Тайлант хугацаанд шүүхийн аливаа маргаанд Нийслэлийн засаг даргыг төлөөлөн оролцоогүй болно.	100%

5	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;	Хүнсний бүтээгдэхүүний чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл аюулгүй хүнсийг захиалгын дагуу Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 13 сургууль, 72 цэцэрлэгт хурдан шуурхай, чирэгдэлгүй нийлүүлэн ажиллаж байна.	100%
6	Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс НЗДТГ, Бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран өөрийн байгууллагын хариуцах индексийн үзүүлэлтийг тогтоох, индексийн суурь түвшинг нягтлах, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлыг 2024 оны 02 дугаар улиралд багтаан хийж гүйцэтгэх;	Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хотын хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
7	Хотын хөгжлийн индексийн өөрийн байгууллагын хамаарах үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, хүрсэн үр дүнг 2024 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тогтоох;	<p>Өөрийн байгууллагад хамаарах төлөвлөсөн 2 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>1.Тус байгууллага нь нийт 32 нэр төрлийн 119 бараа бүтээгдэхүүнийг аюулгүй үзүүлэлт бүрэн шинжилгээний бичигтэй хүнсний бүтээгдэхүүнийг цэцэрлэг, сургуулиудад нийлүүлдэг. Мах, махан бүтээгдэхүүнийг мал эмнэлгийн нэгдсэн системд нэвтэрч, гарал үүслийн бичгийг 7 хоног бүрээр, хүнсний ногооны гарал үүслийг авч цэцэрлэг, сургуулиудад хүргүүлж байна. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт Монгол Улсын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага хангасан байна” гэж заасны дагуу импортоор орж ирсэн хүнсний бүтээгдэхүүнийг импортын гэрчилгээ болон гаалийн мэдүүлгийг үндэслэн хүлээн авч байна. Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн төрийн өмчит сургууль цэцэрлэгүүдэд хүнсний бараа бүтээгдэхүүний шинжилгээний бичгийг цаг тухай бүрт нь хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>2.Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн төрийн өмчит сургууль, цэцэрлэгүүдээс 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс хойш 20 санал, гомдол ирсэн. Тухайн санал гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, нийлүүлэгч аж ахуй нэгжид шаардлага хүргүүлсэн. Багц 15 (компотны материал) нийлүүлж буй аж ахуй нэгж байгууллага нь шаардлагыг биелүүлэхгүй байсан учраас гэрээг цуцалж, тендер зарлаж багц 15 (компотны материал)-д шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Гомдол гарсан бараа, бүтээгдэхүүн нийлүүлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад албан бичиг хүргүүлж, барааны чанарыг сайжруулан чанар, стандартад нийцсэн бараагаар хангаж ажиллаж байна. Мөн хуурай хүнсний 5 агуулахын 160 м.кв</p>	100%

		талбайг, махны хөргүүртэй агуулахын 55 м.кв талбайд цемент цутган тэгшилж, хүнсний агуулахын зориулалттай будгаар будуулан шинэчилж сайжруулан ажиллаж байна.	
8	Хотын хөгжлийн индекс болон тухайн байгууллагын суурь мэдээллийг орон зайд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санд тухай бүр оруулах;	Хотын хөгжлийн индекс тэй холбоотой 2 арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг НЗДТГазарт тайлагнан ажиллаж байна.	100%
9	Чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормыг иргэн аж ахуй нэгж байгууллагуудад сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх;	Өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой норм, дүрэм, стандартыг вэб хуудсаар дамжуулж сурталчилан таниулж ажилласан.	100%
10	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэх;	Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх тухай зорилтод түвшинд тусгаж, Нийслэлийн өмчийн харилцааны газарт 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хүргүүлж, 2024 оны зорилтод түвшин батлагдаж ажилчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлж ажилласан. Нийт ажилчдыг 2 удаагийн эрүүл мэндийн үзлэгт 2,192,000.00 төгрөгөөр хамруулж, 1,704,100.00 төгрөгөөр нэг удаагийн хамгаалах хэрэгсэл материалаар хангаж, тухай бүр нь ажилтныг ажиллах нөхцлөөр хангасан. Байгууллагын дотоод журамд заасны дагуу шинээр орон байранд орсон 2 ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж тус бүр 1,000,000.00 төгрөг, нийт 2,000,000.00 төгрөг, 1 ажилтанд нас барсны тэтгэмж 1,000,000.00 төгрөг, гэр хороололд амьдардаг 9 ажилчдад түлээ, нүүрсний хөнгөлөлтийг үзүүлж 2,888,000.00 төгрөгийг тус тус олгосон. Сар шинийн баярыг тохиолдуулан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж, хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилтнуудын хүүхдүүдийг хүлээн авч баярлуулсан. Нийт ажилтнууд удирдах дээд байгууллагаас болон бусад байгууллага, дотооддоо зохион байгуулсан 15 удаагийн сургалтанд хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн.	100%
11	Чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг өөрийн цахим хуудас болон төрийн үндэсний судалгааны нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх;	2024 онд харилцагч 2 дүүргийн төрийн өмчит 50 цэцэрлэг, сургуулиас 4 удаа сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан. Судалгаанд оролцогчдын санал хүсэлтийг хүлээн авч, бараа бүтээгдэхүүний төрлийг нэмсэн. Мөн төрийн өмчит цэцэрлэгийн сургуулийн нярвууд болон, түгээлтийн багийн ажилчдад 2 удаагийн сургалт зохион байгуулсан. Бараа бүтээгдэхүүн буцаах гомдлыг хүлээн авч, нийлүүлэгч байгууллагад тухай бүр мэдэгдэн чанарыг сайжруулан ажиллаж байна.	100%

12	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;	2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл байхгүй. Нийслэлийн өргөдөл гомдлын цахим erp.ulaanbaatar.mn программаар ирсэн 17 өргөдлийг хүлээн авч ажилд орох 9, ажил хавсран гүйцэтгэх 2, ажлаас чөлөөлөх 4, ажил хавсран гүйцэтгэснийг болих 1 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	100%
13	Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах;	2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар нийслэлийн удирдах ажилтны 24 удаагийн шуурхай зөвлөгөөнд оролцсон. Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 6 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.	100%
14	Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж хүргүүлсэн.	100%
15	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээллэх;	2024 оны жилийн эцсийн байдлаар нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байгууллагын даргын шийдвэрийг байгууллагын цахим хуудас буюу www.bagachuudkhuns.ub.gov.mn -д байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн арга хэмжээ, дүрэм, журам, тушаал, шийдвэр, ажлын байрны сул орон тоо, зохион байгуулагдаж буй арга хэмжээний мэдээлэл зэргийг байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. Bagachuudkhuns.ub.gov.mn цахим хуудсанд шинээр үйл явдлын мэдээ 36 мэдээллийг нийтэлж, давхардсан тоогоор 2250 хүнд хүргэсэн. Фейсбүүк пэйж хуудсанд шинээр үйл явдлын мэдээ 21 гэрэл зураг 30 мэдээллийг нийтэлж, давхардсан тоогоор 5200 хүнд хүргэсэн. Албан тушаалын сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас, пэйж фэйсбүүк хуудсаар дамжуулан нийт 6 удаа байршуулан, 9 ажилтныг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сонгон шалгаруулж ажилд авсан. UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст нэвтрэх эрх байхгүй болно.	100%
16	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;	Нийтийн мэдээллийн ил тод байлгах хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын шилэн дансны хөтлөлтөд 2024 оны 1-ээс 11 дүгээр саруудад нийт 140 мэдээлэл мэдээлэхээс 100 хувийн гүйцэтгэлтэйгээр бүрэн мэдээллэсэн байна. 5,000,000.00 төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого 7,651,852.24 мянган төгрөгийг, 5,000,000.00 төгрөгөөс дээш зарлага 5,255,134.27	100%

		<p>төгрөгийг гүйлгээ гарсан тухай бүрд нь холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж тайлагнасан.</p> <p>2024 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгасан 22 багц ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлаж, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 22 багцад худалдан авах ажиллагааг зарлахад 17 багцад 12 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 5 багцад огт тендерийн материал ирээгүй болно. Үнэлгээ хийх явцад 7 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 3 аж ахуйн нэгж байгууллагад гэрээ байгуулах эрх олгосон. Үүнээс 2 аж ахуй нэгж байгууллагатай 5 багцтай гэрээг байгуулан ажиллаж байгаа бөгөөд 1 аж ахуй нэгж нь тендерийн баримт бичигт заасны дагуу гэрээ байгуулах гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй тул тус тендерийн баталгааг цуцалж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6.2-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгоно гэж заасан тул худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулах шийдвэр гаргасан. Нээлттэй тендер шалгаруулалтыг одоогийн байдлаар 5 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй, нэг ч оролцогч оролцоогүй багцад дахин 6 дахь тендер шалгаруулалтыг зарлан 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр нээлтээ хийн үнэлгээ хийх шатанд явж байна.</p>	
17	<p>Хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал, өгсөн чиг үүргийн биелэлтийг хангаж, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн өмнө хариуцах;</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай А/348 дугаар захирамж, Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газрын 3/748 тоот “Хотоо угаая” уриатай хаврын бүх нийтийн их цэвэрлэгээний дагуу нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай гуу жалганд үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, угаах өнгийг сэргээх зорилготой хаврын их цэвэрлэгээ, Улаанбаатар хотын захирагч бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн шуурхай зөвлөгөөнөөр нийслэлийн хэмжээнд бүх</p>	100%

		нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах үүрэг чиглэлийн хүрээнд “Багачууд хүнс ОНӨААТҮГ”-ын 18 ажилтан 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 12 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл идэвхтэй хамтрагдаж байгууллагын гаднах 50 м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайг 10 удаа цэвэрлэн байгууллагын хайс хашлага, гадна фасат хаяг, үүд довжоог угааж өнгө үзэмжийг сэргээж ажиллаа. Нэгдсэн их цэвэрлэгээний хуваарийн дагуу үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс нарантуулын уулзвар хүртэл зам дагуу явган хүний зам болон нийтийн эзэмшлийн зам талбай хог хаягдлыг 1 удаа цэвэрлэн “Хотоо угаая” аяныг дэмжин ажиллалаа.	
18	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах;	Жилийн эцсийн байдлаар зөвшилцөн ажилласан ажил байхгүй болно.	100%
19	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, түүнтэй хамт баталсан бусад хуулиар олгосон эрхийн хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;	Тус газраас Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, түүнтэй хамт баталсан бусад хуулиар олгосон эрхийн хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг боловсруулж батлуулаагүй болно.	100%
20	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны хэсэгчилсэн гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;	Нийслэлийн Засаг даргын баталсан захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нь 2023 оны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж хангалттай үнэлгээг өгсөн.	100%

ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
БАГАЧУУД ХҮНС ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ



Б.МӨНХНАСАН